



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

"Анирсаг финанс" ХЗХ-нд хадгаламж,
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 15 дугаар зүйлийн 15.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 405 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Анирсаг финанс" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Анирсаг финанс" ХЗХ /Д.Оюунцэцэг/-нд үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН